

2025 03, 26

№ 481

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО ӨЗБ-д

Хүсэлт гаргах тухай

“Ард Кредит ББСБ” ХК-ийн 2025 оны 03 сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 28-ны өдрийн 11.00 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн.

Тус ББСБ нь 14,483 хувьцаа эзэмшигчтэй /2024.12.31 байдлаар/ бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолын хавсралт “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” -ын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд үйлчилгээ үзүүлж буй брокер, дилерийн компаниудад цахим хэлбэрээр түгээн, мэдээлэл хүргэж бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Хавсралт:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын танилцуулга;

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.СҮХБААТАР



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2025 оны 4 сарын 28-ний өдрийн 11.00 цагт**, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 3 сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан 2025 оны 3 сарын 21-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, 2025 оны 4 сарын 04-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 3 сарын 26-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
7. Хурлын даргаар Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганзоригийг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлоолон Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Г.Солонго

Байгууллагын банкны газрын захирал Б.Пүрэвдорж

Бизнес хөгжил хариуцсан захирал Н.Ачит

Маркетинг борлуулалтын мэргэжилтэн Б.Бүжин

Санхүүгийн шинжээч Ш.Пүрэвдорж

Туслах хуульч Г.Буянтогтох

Төслийн менежер М.Хэрлэн

Бүртгэл хяналтын ахлах мэргэжилтэн Ц.Мөнхцэцэг

График дизайнер Б.Хадбаатар

Салбарын менежер Д.Цэнд-Аюуш

9. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 4 сарын 25-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатарт даалгасугай.
11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Тооллогын комиссын дарга:

Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Ч.Даваацэрэн (Ард секюритиз ҮЦК ХХК)

А.Эрхбилгүүн (Ард секюритиз ҮЦК ХХК)

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатарт даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга Ч.Ганзориг болон Хурал зохион байгуулах комиссын дарга (Г.Сүхбаатар) нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 3 сарын 18-ны өдрийн
2025/... тоот тогтоолын Хавсралт №1



**2025 ОНЫ 4 САРЫН 28-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;



**АРД КРЕДИТ ББСБ ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 28-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 1 давхарын салбарт ирж хурлын материалтай танилцан санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны .. сарын .. өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Гийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 3 сарын 18-ны өдрийн
2025/18 тоот тогтоолын Хавсралт №2



**АРД КРЕДИТ ББСБ ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №7)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 сарын 28-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн нэгдэл ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
Компанийн дүрмийн дараах заалтуудад өөрчлөлт оруулах				
1	Компанийн 8.1.3 дахь заалтад “Түйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох” гэж өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Компанийн дүрмийн 8.2 дахь заалтад “Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгох бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ ” гэж өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Компанийн дүрмийн 8.15 дахь заалтад “Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 3. Санхүү, эрсдэл, зээлийн хороо, 4. Цалин, урамшууллын хороо г тус тус байгуулан ажиллуулна” гэж өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Компанийн дүрмийн 8.17 дахь заалтад “ Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Компанийн дүрэмд дараах заалтуудыг нэмж оруулах				
4	Компанийн дүрмийн 8.19 дэх заалтад “Цалин, урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж нэмэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Компанийн дүрмийн 8.19.1 дэх заалтад “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Компанийн дүрмийн 8.19.2 дахь заалтад “Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоон батлах, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Компанийн дүрмийн 8.19.3 дахь заалтад “Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх” гэж нэмэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Дээрх заалтууд нэмэлтээр орсонтой холбогдуулан Компанийн дүрмийн 8.19 дэх заалтын дугаарлалтыг 8.20 болгон өөрчилж “ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцаагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.” гэж нэмэх			
Компанийн дүрмийн дараах заалтуудыг хүчингүй болгох				
9	Компанийн дүрмийн 8.17.9, 8.17.10, 8.17.11 дэх заалтыг тус тус хүчингүй болгох;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 1 давхарын салбарт

ирж хурлын материалтай танилцан санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.

3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны .. сарын .. өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 3 сарын 18-ны өдрийн
2025/... тоот тогтоолын Хавсралт №3



АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Кредит ББСБ ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар боллоо. Хувьцаа эзэмшигч та хурлын өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд ирж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцоно уу.

Компанийн оноосон нэр: Ард Кредит ББСБ ХК

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 2025/... тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах өдөр, цаг, байршил: 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хуралдана.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах тухай;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Бүртгэлийн өдөр: 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх, саналын хуудасны загвар;
3. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт;
4. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл;

Хувьцаа эзэмшигч та өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол **2025 оны 4 сарын 25-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд** Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр барилгын 1 давхарт ирж, эсвэл компанийн www.ardcredit.com цахим хуудсаар хурлын материалтай танилцаад санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр барилгын 17 давхарт

Утас: 77003322

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

2025 оны 4 сарын 28-ны өдөр

№2025/01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар
зүйлийн 7.6 дахь заалт, 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны...дүгээр сарын-ны өдрийн тогтоолоор
гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ДАРГА

Ч.ГАНЗОРИГ

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын .. тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Компанийн 8.1.3 дахь заалтад “Түйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох” гэж;

1.2. Компанийн дүрмийн 8.2 дахь заалтад “Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгох бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ ” гэж;

1.3. Компанийн дүрмийн 8.15 дахь заалтад “Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 3.Санхүү, эрсдэл, зээлийн хороо, 4. Цалин, урамшууллын хороог тус тус байгуулан ажиллуулна”.

1.4. Компанийн дүрмийн 8.17 дахь заалтад “Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчлөх;

2. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах заалтуудыг нэмсүгэй.

2.1. Компанийн дүрмийн 8.19 дэх заалтад “Цалин, урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж;

2.2. Компанийн дүрмийн 8.19.1 дэх заалтад “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

2.3. Компанийн дүрмийн 8.19.2 дахь заалтад “Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоон батлах, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

2.4. Компанийн дүрмийн 8.19.3 дахь заалтад “Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх” гэж нэмэх;

3. Компанийн дүрмийн 8.17.9, 8.17.10, 8.17.11 дэх заалтыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэхүү шийдвэрийн 1, 2, 3-т заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

5. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ